

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/94/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чингис хот

2022 он

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Туяа
Утас: 99028942 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Contents

Contents.....	1
1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.2 Албан шаардлага	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
6. Аудитын тайлангийн хавсралт.....	18
6.1. Албан шаардлага 2021.03.09 №	ХЭА-2022/94/НА-СТА-ТШЗ
Албан шаардлага 2021.03.09 №	ХЭА-2022/94/НА-СТА-ТШЗ
Албан шаардлага 2021.03.09 №	ХЭА-2022/94/НА-СТА-ТШЗ

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.09 № 192
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохиистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>58,781,345.24</u>	<u>73,275,250.96</u>
33	АВЛАГА	6,500,000.00	10,000,000.00
335	Бусад авлага	6,500,000.00	10,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	6,500,000.00	10,000,000.00
34	УРЬДЧИЛГАА	-	11,038,780.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	11,038,780.00
35	БАРАА МАТЕРИАЛ	38,781,345.24	42,250,470.96
354	Хангамжийн материал	33,181,345.24	33,650,470.96
35410	Бичиг хэргийн материал	1,780,675.00	2,405,120.72
35420	Аж ахуйн материал	21,375,670.24	27,741,670.24
35440	Түлш, шатах тослох материал	10,025,000.00	3,503,680.00
35600	Мал амьтад	5,600,000.00	8,600,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	13,500,000.00	9,986,000.00
36300	Тэжээлийн нөөц	13,500,000.00	9,986,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,387,057,979.62</u>	<u>1,432,154,215.78</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,387,057,979.62	1,432,154,215.78
392	Биет хөрөнгө	1,283,103,179.54	1,328,524,415.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	760,387,476.00	799,219,526.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(113,769,501.58)	(162,576,475.46)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	170,451,069.17	229,811,069.17
39204	Хуримтлагдсан элэгдэл	(163,490,381.85)	(173,262,226.53)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	148,870,070.76	163,154,232.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	(95,384,637.03)	(87,564,682.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	75,483,903.34	87,079,686.34
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,822,463.17)	(40,498,482.30)
39209	Зам, гүүрийн байгууламж	683,354,070.00	694,354,070.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(155,147,726.10)	(191,363,601.98)
39217	Ном	10,171,300.00	10,171,300.00
393	Биет бус хөрөнгө	103,954,800.08	103,629,800.12
39301	Програм хангамж	3,478,139.00	1,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,828,138.92)	(974,999.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	103,304,800.00	103,304,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,445,839,324.86</u>	<u>1,505,429,466.74</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>2,622,204.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,622,204.00
413	Өглөг	-	2,622,204.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,622,204.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,445,839,324.86</u>	<u>1,502,807,262.74</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,445,839,324.86	1,502,807,262.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	478,324,947.42	478,324,947.42
51101	Өмч: - төрийн	478,324,947.42	478,324,947.42
512	Хуримтлагдсан үр дүн	606,779,608.66	663,747,546.54
51210	Өмнөх үеийн үр дүн	606,779,608.66	606,779,608.66
51220	Тайлант үеийн үр дүн	-	56,967,937.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	360,734,768.78	360,734,768.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,445,839,324.86</u>	<u>1,505,429,466.74</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	847,108,746.84	1,003,134,396.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	297,123,192.84	94,679,145.72
120	Нийтлэг татварын бус орлого	297,123,192.84	94,679,145.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	297,123,192.84	94,679,145.72
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	525,000.00	360,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	296,598,192.84	94,319,145.72
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	549,985,554.00	908,455,251.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,544,154.00	12,722,351.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,760,304.00	5,952,868.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,783,850.00	6,769,483.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	534,441,400.00	895,732,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	534,441,400.00	895,732,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	655,263,423.95	941,521,600.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	655,263,423.95	941,521,600.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	501,249,504.56	653,630,091.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,080,820.38	250,513,457.00
210101	Үндсэн цалин	158,388,530.06	161,964,816.00
210102	Нэмэгдэл	46,854,815.32	59,811,234.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,570,932.00	6,594,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,266,543.00	22,143,407.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,544,435.48	34,283,780.62
210201	Тэтгэврийн даатгал	20,367,441.48	24,218,805.64
210202	Тэтгэмжийн даатгал	2,312,959.00	2,553,760.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,737,899.00	2,012,765.86
210204	Ажилгүйдлийн даатгал	424,171.00	904,648.30
210205	Эрүүл мэндийн даатгал	4,701,965.00	4,593,800.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,602,487.75	30,931,518.75
210301	Гэрэл, цахилгаан	5,380,387.75	7,952,102.75
210302	Түлш, халаалт	13,080,500.00	22,875,416.00
210303	Цэвэр, бохир ус	141,600.00	104,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,530,923.00	29,146,041.70
210401	Бичиг хэрэг	2,151,490.00	3,224,700.00
210402	Тээвэр, шатахуун	15,576,030.00	18,870,291.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,859,313.00	1,426,800.00
210404	Ном, хэвлэл	168,640.00	136,500.00

**Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,775,450.00	5,487,750.00
2105	Нормативт зардал	720,000.00	910,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	720,000.00	910,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,317,325.00	75,373,820.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	225,000.00
210602	Тавилга	4,276,025.00	140,000.00
210604	Урсгал засвар	8,041,300.00	75,008,820.00
2107	Томилолт, зочны зардал	5,397,000.00	9,330,000.00
210702	Дотоод албан томилолт	5,397,000.00	9,330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,469,578.00	43,437,310.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,202,540.00	37,891,301.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	401,038.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,100.00	171,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,200,000.00
210807	Газрын төлбөр	327,900.00	220,609.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	155,586,934.95	179,704,163.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,654,739.00	65,268,407.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	338,250.00	310,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	115,593,945.95	114,125,755.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	154,013,919.39	287,891,509.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,731,240.00	26,388,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,429,400.00	21,598,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,301,840.00	4,790,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	114,282,679.39	261,502,609.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	114,282,679.39	261,502,609.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>191,845,322.89</u>	<u>61,612,795.91</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	4,644,858.03
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	4,644,858.03
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(4,644,858.03)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>191,845,322.89</u>	<u>56,967,937.88</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	478,324,947.42	360,734,768.78	606,779,608.66	1,445,839,324.86
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	478,324,947.42	360,734,768.78	606,779,608.66	1,445,839,324.86
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	478,324,947.42	360,734,768.78	606,779,608.66	1,445,839,324.86
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	56,967,937.88	56,967,937.88
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	478,324,947.42	360,734,768.78	663,747,546.54	1,502,807,262.74

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛДАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	565,115,604.00	915,315,251.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	525,000.00	360,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	525,000.00	360,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	525,000.00	360,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	525,000.00	360,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	564,590,604.00	914,955,251.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,149,204.00	19,222,351.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,760,304.00	5,952,868.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,388,900.00	13,269,483.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	534,441,400.00	895,732,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	534,441,400.00	895,732,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	554,815,604.00	827,808,401.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	554,815,604.00	827,808,401.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,301,684.61	539,916,891.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,080,820.38	247,324,033.62
210101	Үндсэн цалин	158,388,530.06	155,096,223.62
210102	Нэмэгдэл	46,854,815.32	59,811,234.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,570,932.00	8,094,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,266,543.00	24,322,576.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,544,435.48	34,851,000.00
210201	Тэтгэврийн даатгал	20,367,441.48	24,450,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,312,959.00	2,600,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,737,899.00	2,080,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	424,171.00	520,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,701,965.00	5,200,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,221,987.75	23,383,518.75
210301	Гэрэл, цахилгаан	5,380,387.75	7,952,102.75
210302	Түлш, халаалт	13,700,000.00	15,327,416.00
210303	Цэвэр, бохир ус	141,600.00	104,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,085,313.00	28,155,921.70
210401	Бичиг хэрэг	2,588,110.00	3,844,500.00
210402	Тээвэр, шатахуун	14,558,300.00	20,187,371.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,864,313.00	1,426,800.00
210404	Ном, хэвлэл	228,640.00	136,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	845,950.00	2,560,750.00
2105	Нормативт зардал	720,000.00	910,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	720,000.00	910,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,861,300.00	79,769,820.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,100,000.00	4,000,000.00
210602	Тавилга	10,600,000.00	140,000.00
210604	Урсгал засвар	8,161,300.00	75,629,820.00
2107	Томилолт, зочны зардал	5,397,000.00	9,330,000.00
210702	Дотоод албан томилолт	5,397,000.00	9,330,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,919,578.00	47,564,190.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,652,540.00	42,018,181.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	401,038.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,100.00	171,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,200,000.00
210807	Газрын төлбөр	327,900.00	220,609.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,471,250.00	68,628,407.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,133,000.00	68,318,407.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	338,250.00	310,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	160,513,919.39	287,891,509.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,731,240.00	26,388,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,429,400.00	21,598,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,301,840.00	4,790,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	120,782,679.39	261,502,609.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,782,679.39	261,502,609.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>10,300,000.00</u>	<u>87,506,850.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,300,000.00	87,506,850.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,300,000.00	87,506,850.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,300,000.00	87,506,850.00
223001	Бусад хөрөнгө	10,300,000.00	13,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		74,506,850.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(10,300,000.00)</u>	<u>(87,506,850.00)</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	896,132,900.00	649,446,490.39	246,686,409.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	657,905,900.00	616,614,440.39	41,291,459.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	631,517,000.00	590,225,540.39	41,291,459.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,008,300.00	247,324,033.62	12,684,266.38
210101	Үндсэн цалин	176,475,400.00	155,096,223.62	21,379,176.38
210102	Нэмэгдэл	54,639,000.00	59,811,234.00	(5,172,234.00)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,528,000.00	8,094,000.00	(4,566,000.00)
210105	Гэрээт ажлын хөлс	25,365,900.00	24,322,576.00	1,043,324.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,851,000.00	34,851,000.00	-
210201	Тэтгэврийн даатгал	24,450,800.00	24,450,800.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	2,600,100.00	2,600,100.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,080,000.00	2,080,000.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	520,000.00	520,000.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	5,200,100.00	5,200,100.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,393,100.00	23,383,518.75	9,581.25
210301	Гэрэл, цахилгаан	7,825,000.00	7,952,102.75	(127,102.75)
210302	Түлш, халаалт	15,368,100.00	15,327,416.00	40,684.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	104,000.00	96,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,814,200.00	28,085,921.70	728,278.30
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	3,844,500.00	(844,500.00)
210402	Тээвэр, шатахуун	21,000,000.00	20,187,371.70	812,628.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,944,000.00	1,356,800.00	587,200.00
210404	Ном, хэвлэл	271,000.00	136,500.00	134,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,599,200.00	2,560,750.00	38,450.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	910,000.00	90,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	910,000.00	90,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	136,354,300.00	134,444,620.00	1,909,680.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,950,500.00	43,950,500.00	-

**Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210602	Тавилга	15,983,000.00	14,864,300.00	1,118,700.00
210604	Урсгал засвар	76,420,600.00	75,629,620.00	790,980.00
2107	Томилолт, зочны зардал	10,000,300.00	9,330,000.00	670,300.00
210702	Дотоод албан томилолт	10,000,300.00	9,330,000.00	670,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,196,700.00	46,618,039.00	20,578,661.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,400,000.00	41,072,030.00	20,327,970.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	461,400.00	432,000.00	29,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	503,500.00	500,000.00	3,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	252,000.00	171,400.00	80,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	86,000.00	22,000.00	64,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,200,000.00	4,200,000.00	-
210807	Газрын төлбөр	293,800.00	220,609.00	73,191.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,899,100.00	65,278,407.32	4,620,692.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,092,600.00	64,968,407.32	4,124,192.68
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	806,500.00	310,000.00	496,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,388,900.00	26,388,900.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,388,900.00	26,388,900.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,598,900.00	21,598,900.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,790,000.00	4,790,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	238,227,000.00	32,832,050.00	205,394,950.00
2200	Дотоод эх үүсвэрээр	238,227,000.00	32,832,050.00	205,394,950.00
223001	Бусад хөрөнгө	238,227,000.00	32,832,050.00	205,394,950.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	896,132,900.00	649,446,490.39	246,686,409.61
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	895,732,900.00	649,086,490.39	246,646,409.61
132001	Орон нутгийн төсвөөс	895,732,900.00	649,086,490.39	246,646,409.61
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	400,000.00	360,000.00	40,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000.00	360,000.00	40,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,222,351.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,222,351.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,366,151.00
2104	Хангамж, бараа материалын зардал	70,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	946,151.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	946,151.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,350,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,350,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,856,200.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	14,856,200.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,222,351.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,222,351.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,952,868.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,269,483.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Туяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүргийг “харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах...” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 655.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 5,904.2 сая төгрөг болж, өмнөх оноос 115.1 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт / сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	6.5	10.0	3.5
Урьдчилгаа	-	11.0	11.0
Бараа материал	52.3	52.2	(0.1)
Үндсэн хөрөнгө	1,387.0	1,432.2	45.2
Нийт хөрөнгө	1,445.8	1,505.4	59.6
Өр төлбөр	-	2.6	2.6
Засгийн газрын оруулсан капитал	478.3	478.3	-
Хуримтлагдсан үр дүн	606.8	663.8	57.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	360.7	360.7	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,445.8	1,505.4	59.6

Авлага дансны үлдэгдэл 10.0 сая төгрөг болж 3.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд шилжүүлсэн зураг төсвийн үнийг авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 11.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ажил гүйцэтгүүлэхээр урьдчилж гарсан зардлыг бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,432.2 сая төгрөг болж 45.2 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 89.4 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн, 74.5 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 31.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 663.8 сая болж 57.0 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 156.0 сая төгрөгөөр буюу 18.4 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт 361.3 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 202.4 сая төгрөгөөр, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1.8 сая төгрөгөөр, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.0 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 286.2 сая төгрөгөөр буюу 43.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин хөлс, шимтгэлийн зардал 24.1 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 6.6 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 63.0 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 18.0 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 24.1 сая төгрөгөөр, урсгал шилжүүлэг 133.9 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 364.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 531.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 896.1 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 896.1 сая төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс 895.7 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 0.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 895.7 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 0.4 сая, нийт 896.1 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 649.4 сая төгрөгийг зарцуулж 246.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 5.9 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 13.3 сая нийт 19.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийт мэдээлбэл зохих 1,193.9 сая төгрөгийн 117 мэдээллээс 884.6 сая төгрөгийн 103 мэдээллийг мэдээлж, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 71.2 сая төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 238.1 сая төгрөгийн 5 гүйлгээ, нийт 309.3 сая төгрөгийн 12 мэдээллийг мэдээлээгүй, 2 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдлийг тулгахаар шийдвэрлэв.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 365.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайланд 21.0 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 324.4 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 20.0 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

1. Сумын төвийн хаягжуулалтын ажил гүйцэтгүүлэхээр гүйцэтгэгчид урьдчилан шилжүүлсэн 11.0 сая төгрөгийг зардалд хаасныг урьдчилж гарсан зардлаар бүртгүүлж залруулсан.
2. Тайлант онд нутгийн удирдлагын ордны зураг төсвийн үнэд урьдчилан шилжүүлсэн 10.0 сая төгрөгийг авлагаар бүртгээгүйг залруулж авлагаар тусгуулав.

4.2 Албан шаардлага

Аудитаар залруулагдаагүй 324.4 сая төгрөгийн зөрчлийг дахин давтахгүй байх 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Батлагдсан төсвийн хүрээнд тэвчиж болох 14.5 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна.
2. Шилэн дансны цахим хуудсанд нийт мэдээлбэл зохих 1,193.9 сая төгрөгийн 117 мэдээллээс 884.6 сая төгрөгийн 103 мэдээллийг мэдээлж, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 71.2 сая төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 238.1 сая төгрөгийн 5 гүйлгээ, нийт 309.3 сая төгрөгийн 12 мэдээллийг мэдээлээгүй, 2 мэдээллийг хугацаа хоцроосон байна.
3. Цалингийн зардлын 0.6 сая төгрөгийг нийгмийн шимтгэлийн даатгалын зардлаас төлж, батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй байна.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сум тохижилтын ОНӨҮГ-т гэрээт ажилд шилжүүлсэн 20.0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийн тайлан байхгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээт ажилд шилжүүлсэн зардлын гүйцэтгэлийн тайланг тухай бүр гүйцэтгэгчээр гаргуулан хяналт тавьж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын Тамгын газар	5	56.2	2	21.0			2	15.1	1	20.0
Дүн		5	56.2	2	21.0			2	15.1	1	20.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын Тамгын газар	1	309.3					1	309.3		
Дүн		1	309.3					1	309.3		
Нийт дүн		6	365.5	2	21.0			3	324.4	1	20.0

6. Аудитын тайлангийн хавсралт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 124/А2370447
ХТХ - 2022/94/НН-ЕТА-ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн хэмжээнд тэвчиж болох 14.5 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.5 “салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Эрдэнэчимэг, нягтлан бодогч М.Мөнхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Н.ТУЯА

Д.ОЮУНТУЯА

2317144297

СИОА9046-2074082



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 128/А.2370447
ХӨА 2022/94/НА СТА ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд нийт мэдээлбэл зохих 1,193.9 сая төгрөгийн 117 мэдээллээс 884.6 сая төгрөгийн 103 мэдээллийг мэдээлж, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 71.2 сая төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 238.1 сая төгрөгийн 5 гүйлгээ, нийт 309.3 сая төгрөгийн 12 мэдээллийг мэдээлээгүй, 2 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулдаггүй зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Эрдэнэчимэг, нягтлан бодогч М.Мөнхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Н.ТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 126/А 2370447
ХТТ-2022/04/НА-СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлын 0.6 сая төгрөгийг нийгмийн шимтгэлийн даатгалын зардлаас төлж, батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Эрдэнэчимэг, нягтлан бодогч М.Мөнхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ахлах аудитор

Аудитын менежер



Н.Туяа

Д.Оюунтуяа